

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН  
2016 ОНЫ ЭХНИЙ 01 САРЫН ДҮНГИЙН  
ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА**



**МӨНГӨ, БАНК, ДААТГАЛ**

2016 оны эхний 01 сарын байдлаар аймгийн төсвийн орлогын дүн 402.6 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 14.5 сая төгрөгөөр буюу 3,6 хувиар буурсан байна. 2016 оны эхний 01 сарын байдлаар нийт орлогын болон татварын орлогын төлөвлөгөөг Эрдэнэцогт, Баян-Овоо, Богд, Өлзийт, Баацагаан, Бууцагаан сумууд биелүүлсэн байна.

Орлогын төлөвлөгөөний биелэлтийг төрөл дээр нь авч үзвэл: ААНБ-ын орлогын татвар 2,7 сая төгрөг, НӨАТатвар 0,9 сая төгрөг, газрын төлбөр 1,0 сая төгрөг, ИОТТХ 8,5 сая төгрөг, ЦХТА орлого 112,3 сая төгрөгөөр тус тус тасарч бусад нэр төрөлд биелэлээ.

Нийт орлогод ААНБ-н орлогын албан татвар 0,4 хувь, нэмүү өртгийн албан татвар 8,0 хувь, ЦХТА орлого 61,6 хувь, авто тээвэр өөрөө авагч хэрэгслийн татвар 1,2 хувь, хүү торгууль 6,7 хувь бусад төлбөр хураамж 22,1 хувийг эзэлж байна.

2016 оны 01 дүгээр сарын эцэст иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 46807,6 сая төгрөг, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 119304,2 сая төгрөгт хүрчээ. Чанаргүй зээл 1480,7 сая төгрөгт хүрсэн нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1,2 хувийг эзэлж байна.



**ЭРҮҮЛ МЭНД**

2016 оны эхний 01 сарын байдлаар аймгийн хэмжээнд 158 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 54 төрөлтөөр буурсан байна. Нийт төрсөн эхийн 90,5 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт, сум дундын эмнэлэгт 3.8 хувь, 5,7 хувь нь сумын эмнэлэгт төрж, Аймгийн төвд гэрийн төрөлтийн тохиолдол бүртгэгдэж, нийт төрөлтөд гэрийн төрөлтийн эзлэх хувь 1,2 байна.

Нийт амьд төрсөн 158 хүүхдийн 1 нь ихэрлэж, 1,2 хувь нь дутуу төрж, 99,8 хувь нь 1 цагийн дотор хөхөө амласан байна. Нялхасын эндэгдэл 1000 амьд төрөлтөд эхний 01 сарын байдлаар 37,7 байна.

Эхний 01 сарын байдлаар архаг болон цочмог халдварт өвчний гаралтыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад трихоминиаз 11, гар хөл амны өвчин 18, хүйтэн 26 тохиолдлоор өссөн бол салхин цэцэг 15, тэмбүү 6, арьсны мөөгөнцөр 4, сүрьеэ 6, гахайн хавдар 2 тохиолдлоор тус тус буурсан байна.

Аймгийн хэмжээнд эхний 01 сарын байдлаар нас баралтын 38 тохиолдол бүртгэгдсэний 31,5 хувь нь эмнэлэгт нас барснаас 10,5 хувь нь хоног болоогүй нас барсан нь өнгөрсөн оны мөн үеэс буурсан байна./2015 онд 12,2/

Түргэн тусламжийн дуудлага өнгөрсөн оны эхний 01 сард 1574 байсан бол энэ оны эхний 01 сарын байдлаар 1290 болж 284 дуудлага буюу 18,1 хувиар буурсан байна. Нийт дуудлагын 21,8 хувийг алсын дуудлага эзэлж байна.



## АЖ ҮЙЛДВЭР

2016 оны эхний 01 сарын байдлаар аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт 4971093 мянган төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 20491 мянган төгрөгөөр буюу 9,9 хувиар буурчээ.

Эхний 01 сарын байдлаар аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг авч үзэхэд урьд оны мөн үеэс нарийн боов 2.5 тн-оор, талх 2.0 тн-оор, хоормог 0.4 мян.литр, түгээсэн цэвэр ус 6.9 мян.м3-ээр тус тус өссөн байна.

### Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалт өссөн дүнгээр /мян.төг/

	2014	2016	2016.01/2015.01
Нийт борлуулалт	<b>476289,4</b>	<b>888884,1</b>	186,6

### Аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт /өссөн дүнгээр/

Бүтээгдэхүүний нэрс	хэмжих нэгж	Нэгдүгээр сар		
		2015	2016	2015.12/2014.12
Тараг	Мян.л	0.2	0.3	150.0
Хоормог	Мян.л	0.6	1.0	166.7
Нарийн боов	тн	4.2	7.5	178.6
Талх	тн	7.6	9.6	126.3
Түгээсэн цэвэр ус	Мян.м3	19.7	26.6	135.0



## ХӨДӨӨ АЖ АХУЙ

Мал тооллогын дүнгээр аймгийн хэмжээнд 3771867 толгой мал тоолуулсны дотор тэмээ 44496, адуу 141338, үхэр 189019, хонь 1082565, ямаа 2314449 толгой тоологдож, нийт малын тоо өнгөрсөн оныхоос 8,8 хувь буюу 306,0 мянгаар өссөн.

Баацагаан, Баянбулаг, Баянговь, Баянлиг, Баян-Өндөр, Баян-Овоо, Баянцагаан, Богд, Бөмбөгөр, Бууцагаан, Гурванбулаг, Жаргалант, Жинст, Өлзийт, Хүрээмарал, Шинэжинст зэрэг 16 сум малаа 5 төрөл дээр нь өсгөжээ.

2016 оны 1 сарын байдлаар аймгийн хэмжээнд 9345 мал хорогдсон. Хорогдсон малын 1.5 хувийг адуу, 12.3 хувийг үхэр, 30.0 хувийг хонь, 60.0 хувийг ямаа эзэлж байна. Хамгийн их хорогдолтой нь Бууцагаан, Хүрээмарал, Өлзийт сумд байна.

Сумын нэр	Хорогдсон мал					
	Бүгд	Үүнээс				
		Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Баянхонгор	127			1	50	76
Баацагаан	200					200
Баянбулаг	273		6	34	110	123
Баянговь	0					
Баянлиг	0					
Баян-Овоо	269		2	6	41	220
Баян-Өндөр	57				32	25
Баянцагаан	0					
Богд	17	2				15
Бөмбөгөр	0					
Бууцагаан	2244		18	26	600	1600
Галуут	522		33	237	110	142
Гурванбулаг	206		20	45	56	85
Жаргалант	793		2	598	89	104
Жинст	196				29	167
Заг	182		8	11	47	116
Өлзийт	1745		20	51	392	1282
Хүрээмарал	2072			27	756	1289
Шинэжинст	0					
Эрдэнэцогт	442		32	115	116	179
	9345	2	141	1151	2428	5623



## **НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ**

2016 оны эхний 01 сард тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэрт 1754.7 сая төгрөг, тахир дутуугийн тэтгэвэрт 351 сая төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 59.6 сая төгрөг, цэргийн тэтгэвэрт 39.1 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжид 2.4 сая төгрөг, жирэмсэн болон амаржсаны тэтгэмжид 56.9 сая төгрөг, оршуулгын тэтгэмжид 9.4 сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэрт 6.6 сая төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 2.8 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмжид 2.4 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас эмчилгээний эмийн зардалд 250.0 сая төгрөг тус тус олгожээ.

Нийгмийн халамжийн сангаас 2016 оны 1 сард 1845 хүнд 227,9 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр олгосон байна. 2016 оны 01 сард нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай 5184 иргэнд 127,4 сая төгрөгийн хөнгөлөлт, мөнгөн тусламж, 410 ахмадад 6,6 сая төгрөгийн нэг удаагийн хөнгөлөлт тусламж, хөгжлийн бэрхшээлтэй 195 иргэнд 5,3 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж олгожээ.



## **ГЭМТ ХЭРЭГ**

2016 оны эхний 01 сард аймгийн хэмжээнд нийт 32 хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5 нэгжээр буюу 13,5 хувиар буурсан. Хэргийн илрүүлэлт 33,3 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 8,3 пунктээр өссөн. Хэргийн гаралт 4 суманд буурч, 5 суманд өсөж, 2 суманд ижил түвшинд байна. Хүчин 1 нэгжээр буюу 100 хувь, өмчин хулгай 2 нэгжээр буюу 15 хувь, малын хулгай 1 нэгжээр буюу 14 хувь, хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 2 нэгжээр буюу 100 хувь, бусад гэмт хэрэг 2 нэгжээр буюу 40 хувь, насанд хүрээгүй хүнээс үйлдсэн гэмт хэрэг бүртгэгдээгүй байгаа нь 4 нэгжээр буюу 100 хувь тус тус буурсан. Гэмт хэрэгт 28 хүн холбогдон шалгагдсан ба үүнээс эмэгтэй 3, 18-с дээш насны 28 хүн байна. Гэмт хэргийн улмаас 35 иргэн хохирч, 20 хүн гэмтсэн байна. 34 сая төгрөгийн хохирол учирснаас 13,3 сая төгрөгийг төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлт 40 хувьтай байна.

Бусдын бие мах бодид гэмтэл учруулах хэрэг 1 нэгжээр буюу 7,0 хувь, иргэдийн өмчийн хулгай 1 нэгжээр буюу 25 хувь, дээрэм танхай 1 нэгжээр буюу 100 хувь, өссөн байна.

Харин дээрэм 4 нэгжээр буюу 1,3 дахин, залилан 1 нэгжээр буюу 25 хувь, малын хулгай, булаалтын гэмт хэргүүд өнгөрсөн оны мөн үетэй ижил түвшинд байна.



100.6	102.3	100.0	100.0	102.7	100.3	100.0	100.0	100.0	100.0	100.0	89.3	100.9
-------	-------	-------	-------	-------	-------	-------	-------	-------	-------	-------	------	-------

Нэгжээр илэрхийлсэн шийтгэл ойлгоу өсөж, 1 үзэж, өөрчлөлтөөр өөрчлөгдсөн

Төлөв

Өөрчлөлт	НА	Өөрчлөлт	Н	л	Төлөв	Төлөв,		Н	Л	з	Төлөв	з
Өөрчлөлт	Өөрчлөлт	Өөрчлөлт, Өөрчлөлт	Өөрчлөлт	Өөрчлөлт	Өөрчлөлт	Өөрчлөлт	с	Өөрчлөлт	Өөрчлөлт	Өөрчлөлт	Өөрчлөлт	Өөрчлөлт
	Өөрчлөлт		Өөрчлөлт	А	Өөрчлөлт	А		ү	Төлөв	А	Өөрчлөлт	А
100.6	102.3	100.0	100.0	102.7	100.3	100.0	100.0	100.0	100.0	100.0	89.3	100.9

### СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС